



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 01 өдөр

Дугаар A/193

Батширээт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдсэн "Номгон" агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөг хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:


Ажлын хэсгийн ахлагч: Б.Төрмөнх - Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Мөнх-Очир - Байгаль орчны хяналтын улсын
байцаагч

Б.Сансармаа - Байгаль хамгаалагч

2. Ажлын явцад хяналт тавих ажлыг зохион байгуулж, ажлын үр дүнг хүлээн авсан акт үйлдэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Төрмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501381